



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

Бүтээлч саналын хайрцаг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Олон нийтийн оролцоог хангах, иргэдээс ирүүлсэн бүтээлч санал, санаачилгыг Тер, засгийн бодлого шийдвэрт тусган хэрэгжүүлэх зорилгоор дүүргийн хэмжээнд хороо бүрт бүтээлч саналын хайрцгийг ажиллуулсугай.

2. Бүтээлч саналын хайрцаг ажиллуулах журмыг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Бүтээлч саналын хайрцаг ажиллуулахад шаардагдах зардал 1254000 /нэг сая хоёр зуун тавин дөрвөн мянга/ төгрөгийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Э.Буян-Өлзий/-д зөвшөөрсүгэй.

4. Хайрцагаар ирүүлсэн иргэдийн бүтээлч саналыг хүлээн авч нэгтгэн, ан холбогдолоор нь эрэмблэн улирал тутамд Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж байхыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны Иргэний оролцооны хэлтсийн дарга /Т.Уламбаяр/-д даалгасугай.

ДАРГА



Д БАТ-ЭРДЭНЭ

## **БҮТЭЭЛЧ САНАЛЫН ХАЙРЦАГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг зүйл**

- 1.1. Бүтээлч саналын хайрцгийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Бүтээлч саналын хайрцгийг хорооны Иргэдийн Нийтийн Хурлын дарга хариуцан ажиллуулна.
- 1.3. Бүтээлч саналын хайрцаг, санал өгөх хуудасны загвар, ашиглах журмыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид батална.
- 1.4. Бүтээлч саналын хайрцгийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба нэгдсэн журмаар бэлтгэж хороодод хүргүүлнэ.

### **Хоёр. Бүтээлч саналын хайрцгийг ашиглах**

- 2.1. Бүтээлч саналын хайрцгийг дараах санал авах ажиллагаанд ашиглана:
  - 2.1.1. Улс, Нийслэл, дүүрэг, хороог хөгжүүлэх талаар иргэдээс гаргаж буй тооцоо судалгаатай бүтээлч санал, санаачилга
  - 2.1.2. Хөрөнгө оруулалт, тохижилт, бүтээн байгуулалтын чиглэлийн санал
  - 2.1.3. Иргэдийн оролцоотой хийгдэх бүтээн байгуулалтын ажлын санал
  - 2.1.4. Иргэд, олон нийтийн оролцоог дэмжих чиглэлийн санал
  - 2.1.5. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлийн санал
  - 2.1.6. Олон улсын стандартыг нэвтрүүлэх чиглэлийн санал
  - 2.1.7. Дүүргээс зохион байгуулж буй аливаа үйл ажиллагааг сурталчлан таниулах чиглэлийн санал
  - 2.1.8. Төсөө, хөрөнгө, мөнгө, материалын зарцуулалтыг бууруулах чиглэлийн санал
- 2.2. Саналын хайрцгийг энэ журмын 2.1-д зааснаас бусад үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.
- 2.3. Хороодод хуваарилсан бүтээлч саналын хайрцгийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эд хөрөнгийн бүртгэлд бүртгэж, жил бүр тоолж хадгална.
- 2.4. Бүтээлч саналын хайрцгийг хороод иргэдэд ил харагдахуйц байршуулах бөгөөд гал, усны болон гэнэтийн бусад аюулд өртөхөөргүй байдлаар албан байранд байрлуулна.
- 2.5. Хороо нь бүтээлч саналын хуудас бүхий саналын хайрцгийг гээгдүүлсэн, үргэдүүлсэн, алдсан тохиолдолд өөрсдөө бүрэн хариуцах бөгөөд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд нэн даруй мэдэгдэх ба үргэдүүлсэн болон эвдэж гэмтээсэн этгээдээр үнийг төлүүлэх арга хэмжээ авна.

### **Гурав. Санал бүрдүүлэхэд тавих шаардлага**

- 3.1. Иргэд санал өгөхдөө тусгайлсан загварын "Бүтээлч санал өгөх хуудас"-ыг ашиглана.

3.2. "Бүтээлч санал өгөх хуудас" нь дараах агуулгатай байна.

- 3.1.1. Санал, санаачлагын агуулга
- 3.1.2. Хэрэгжүүлэх арга зам
- 3.1.3. Хүрэх үр дүн
- 3.1.4. Санал гаргагчийн овог, нэр
- 3.1.5. Оршин суугаа хаяг
- 3.1.6. Холбоо барих утас, цахим хаяг

3.3. Энэ журмын 2.1-т заасан удирдамж, чиглэлээс өөр санал, санаачлагыг агуулсан, эсвэл энэ журмын 3.2-т заасан шаардлагыг хангаагүй саналыг хүчингүйд тооцно.

#### **Дөрөв. Санал хүлээн авах**

4.1. Бүтээлч саналыг хорооны ажлын байранд байрлуулсан хайрцгаар хүлээн авна.

4.2. Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга Баасан гараг бүр хайрцгаар ирүүлсэн саналыг бүртгэн Хурлын ажлын албанд хүргүүлнэ.

4.3. Бичгээр ирүүлсэн бүтээлч санал санаачлагыг Иргэдийн санал хүсэлт, нийгмийн санаа бодол тандалт судалгаа хариуцсан ажилтан хүлээн авч, дарааллын дагуу бүртгэлийн дэвтэрт бүртгэж, мэдээг 7 хоног бүр удирдлагад, улирал тутам тэргүүлэгчдэд танилцуулна.

4.4. Хайрцгаар ирүүлсэн бүтээлч саналыг ач холбогдол бүхий байдлаар нь эрэмбэлэн хэлэлцэж, шинэлэг санааг турших, нэвтрүүлэх талаар төлөвлөгөө боловсруулан ажиллана.

4.5. Төлөвлөгөөнд бүтээлч саналыг туршиж нэвтрүүлэхэд гарах зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, үр ашгийн бодит дүнг хэрхэн хянах талаар тодорхой зааж, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэнэ.

#### **Тав. Урамшуулал**

5.1. Бүтээлч саналын хайрцгийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ач холбогдолтой саналуудыг үнэлж урамшуулж болно.

5.2. Тодорхой сэдвээр зарласан болон жилийн тэргүүний бүтээлч саналыг тусгайлан шалгаруулж оны тэргүүний бүтээлч санал гаргагч өргөмжлөл 100000 төгрөгөөр шагнаж урамшуулна.

#### **Зургаа. Бүтээлч саналын хайрцгийг сурталчилах, тогтворжуулах**

6.1. Бүтээлч саналын хайрцгийг сурталчлах, тогтвортой, үр дүнтэй байлгах зорилгоор Хурлын ажлын албаны зүгээс дараах ажиллуудыг зохион байгуулна.


6.2. Саналыг журамд заасны дагуу шуурхай дүгнэх, урамшуулах

6.2.1. Тэргүүний саналуудыг сонин, вэб хуудсаар сурталчлах

6.2.2. Тодорхой сэдвээр санал авах ажлыг зохион байгуулах

6.2.3. Бүтээлч саналын хайрцгийг сурталчлах тогтворжуулах талаар шинэ ажиллуудыг байнга санаачилж байх

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 05 сарын  
27-ны өдрийн 27 дугаар тогтоолын  
хоёрдугаар хавсралт



Шаардагдах зардлын төсөв

№	Шаардагдах зардал	Төлөвлөсөн	Хянасан
1	Бүтээлч саналын хайрцаг 26 см х 37см=66000᠒ 19 ш х 66000᠒=1254000᠒	1254000	1254000
2	Дүн	1254000	1254000

Хянасан: Нягтлан бодогч


Б.Буян-Өлзий

Төлөвлөсөн: Иргэний оролцооны хэлтсийн  
ажилтан

Н.Янжинлхам

## САНАЛ ХҮСЭЛТИЙН ХАЙРЦАГНЫ ТАНИЛЦУУЛГА

### ЗАХИАЛАГЧИЙН ХҮСЭЛТЭЭР ТОМСГОЖ, ӨӨРЧИЛСӨН ХЭМЖЭЭ



- Акриллаар хийгдсэн тул өнгөлөг чамин харагддаг, хүний анхаарал татахуйц загвартай, бүх өнгөний сонголттой.
- Хоёр талдаа бал, санал хүсэлт бичих жижиг цаас байршуулах зориулалттай.
- Баг бөх цоожтой.
- Нэгж үнэ: 60 000 төгрөг энэ үнэнд НӨАТ багтаагүй болно.

ЭС СИ ЭЛ ХХК

88113629, 96663629

**САНАЛ ӨГӨХ ХУУДАС**

Санал гаргагчийн овог, нэр .....  
Оршин суугаа хаяг .....  
Холбоо барих утас, .....  
И-мэйл хаяг .....  
Огноо .....

Санал, санаачлагын агуулга  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Хэрэгжүүлэх арга зам**  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Хүрэх үр дүн**  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Арын хуудсанд**

**САНАЛ ХҮЛЭЭН АВАГЧИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ**

Саналыг хүлээн авч бүртгэсэн  
огноо, дугаар .....

Саналыг удирдлагад танилцуулсан  
огноо, дугаар .....